

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



УЛСЫН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БИЙ БОЛСОН ХӨРӨНГИЙГ
ТҮРЭЭСЛҮҮЛЭН ОЛСОН 301.5 СЯА ТӨГРӨГИЙГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УРСГАЛ
ЗАРДАЛД ЗАРЦУУЛЖ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ӨГӨӨЖИЙГ БУУРУУЛЖ
БАЙНА.

АУДИТЫН КОД: ХӨА-2024/28-21-ШТА-ГА

Хөвсгөл аймаг
2024 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх
аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: З.Даваадорж

Утас: 89100230 Цахим хаяг: Davaadorjz@audit.gov.mn

Аудитор: Н.Гүрбазар

Утас: 99979050 Цахим хаяг: gurbazarn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.
https://audit.mn/?page_id=579

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

Хөвсгөл аймаг дахь
Төрийн аудитын газар

Тэргүүлэх аудитор

А.Эрдэнэбаатар

Аудитын менежер

Б.Тэгшдэлгэр

Ахлах аудитор

З.Даваадорж

Аудитор

Н.Гүрбазар

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл гарвал
70384043 дугаарын утас,
70383793 дугаарын
факсаар харилцана уу.

ХАЯГ: Мөрөн сум Аймгийн
ЗДТГ-ын “А” корпус 3
давхар

Цахим хаяг:

audit.mn/?page_id=579

2024 оны 04 дүгээр сар

Товчилсон үгийн жагсаалт

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Ерөнхий мэдээлэл

Бүлэг А. Харьяалах яамд зарим төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг үндэслэлтэй тооцоогүй байна.

А.1. Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцээгүй төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.

А.2. Өмнөх оноос үргэлжлэн хэрэгжиж буй 4 төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 299.1 сая төгрөгөөр зөрүүтэй тооцсон байна..

А.3. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон байна.

Бүлэг Б: Гүйцэтгэгч гэрээнд заасан ажлыг хугацаанд гүйцэтгээгүй, захиалагчийн хяналт хангалтгүй байгаагаас зарим төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаандаа дуусаагүй байна.

Б.1. Нийтийн халуун усны барилга /Хөвсгөл, Баянзүрх, Алаг-Эрдэнэ сум/, Ахмадын төвийн барилга /Хөвсгөл, Баянзүрх, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сум/ төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаа, зураг, төсөв, техникийн шаардлагын дагуу хэрэгжүүлээгүй байна.

Б.2. Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс нь захиалагчийн чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Б.3. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгэх шийдвэр ирүүлээгүй тул 16,861.0 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээний хүрээнд бий хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

Бүлэг В: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хүлээн авсан хөрөнгийг одоог хүртэл ашиглахгүй байгаа нь тэргүүн ээлжид хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагатай төсөл арга хэмжээг төлөвлөөгүйг харуулж байна.

В.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн ашиглалт хангалтгүй зарим төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг одоог хүртэл ашиглаагүй, түрээсийн орлогыг үйл ажиллагааны зардалд зарцуулж байгаа нь төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна.

В.2. Эрх шилжсэн улсын төсвийн хөрөнгө оруулалт 61 хувийн хэрэгжилттэй байна.

В.3. Хөрөнгө оруулалтын санхүүжилт гүйцэтгэлийн талаарх мэдээллийг publicinvestment.gov.mn, shilendans.gov.mn цахим сайтуудад хөрөнгө оруулалт, санхүүжилтийн талаарх мэдээллийг тогтмол оруулж ажилласан байна

В.4 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн биелүүлээгүйгээс зөрчил давтагдан гарсан байна.

Дүгнэлт

Зөвлөмж

Зөрчлийн жагсаалт

Тайлангийн хавсралтууд

Холбогдох байгууллагуудын санал

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХӨА	Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар
ШТА	Шууд тайлагнах аудит
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХШҮХ	Хяналт, шинжилгээ-үнэлгээний хэлтэс
СХДАА	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
ХАА	Худалдан авах ажиллагаа
НББ	Нягтлан бодох бүртгэл



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/10

Мөрөн сум

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол улсын Ерөнхий аудиторын 2023 оны “Эрх шилжүүлэх тухай” А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, аудитаар тогтоосон акт, албан шаардлагуудыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, Засаг даргын тамгын газрын дарга, Орон нутгийн өмчийн газар, Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төвийн дарга нарт хүргүүлсүгэй.

3. “Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитын зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэн биелэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (Г.Мөнгөнхуяг), аймгийн Засаг дарга (П.Лхагважав), Засаг даргын тамгын газрын дарга (Б.Батбилгүүн), Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа), Барилга захиалагчийн хяналтын төв ААТҮГ-ын захирал (Х.Даваасүрэн) нарт зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (З.Даваадорж)-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер (Б.Тэгшдэлгэр)-т даалгасугай.

6. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2024 оны 6 дугаар сарын 20-ний өдрийн дотор архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (З.Даваадорж)-т үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР



6724010030

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн *Ана* тоот тушаалын хоёрдугаар хавсралт

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн гүйцэтгэлийн аудитын акт, албан шаардлагын жагсаалт

д/д	Акт, албан шаардлагын утга	Хариуцах байгууллага	Акт, албан шаардлагын дугаар
1	Төлбөр барагдуулах тухай	Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс	90/A2270438/ХӨА-2024/28-21-ШТА-ГА
2	Зөрчил арилгах тухай	Аймгийн Засаг дарга	71/A2270438/ХӨА-2024/28-21-ШТА-ГА
3	Зөрчил арилгах тухай	Аймгийн Засаг дарга	72/A2270437/ ХӨА-2024/28-21-ШТА-ГА
4	Зөрчил арилгах тухай	Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс	73/A2270437/ ХӨА-2024/28-21-ШТА-ГА
5	Зөрчил арилгах тухай	Орон нутгийн өмчийн газар	74/A2270437/ ХӨА-2024/28-21-ШТА-ГА
6	Зөрчил арилгах тухай	Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс	75/A2270437/ ХӨА-2024/28-21-ШТА-ГА
7	Зөрчил арилгах тухай	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	76/A2270438/ХӨА-2024/28-21-ШТА-ГА
8	Зөрчил арилгах тухай	Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ААТҮГ	77/A2270438/ХӨА-2024/28-21-ШТА-ГА
9	Зөрчил арилгах тухай	Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ААТҮГ	78/A2270438/ХӨА-2024/28-21-ШТА-ГА

--ooOoo--

Дүгнэлт гаргах ажлын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл:

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоол, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

“Улс төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан нэгдсэн төлөвлөгөө, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын баталсан дэд төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан, дүнг Үндэсний аудитын газар болон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- ❖ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж, санхүүжүүлсэн эсэх,
- ❖ Хөрөнгө оруулалтын төсөл арга, хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж хүлээн авсан эсэх,
- ❖ Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх,

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад 2023 онд эрх шилжин хэрэгжсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлсэн аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, Санхүү, төрийн сангийн хэлтэс, гүйцэтгэгч аж ахуй нэгж болон хяналтын чиг үүрэг бүхийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв, Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба, Хяналт, шинжилгээ-үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, Алаг-Эрдэнэ, Баянзүрх, Арбулаг, Тосонцэнгэл, Их-Уул, Тариалан, Чандмань-Өндөр, Цагаан-Үүр, Түнэл сумдын холбогдох төрийн байгууллага, ажлын хэсгийн үйл ажиллагааг хамруулсан.

Хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний бодит гүйцэтгэлд хийх хяналтыг 20,958.7 сая төгрөгийн 15 төсөл, арга хэмжээ буюу нийт төсөвт өртгийн 93 хувийг хамруулан гүйцэтгэсэн.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 300, 3000-3100, 5400-5499, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудитын Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудитын Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим” MNS 6817-7:2020 “Төрийн аудит Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим МУ-ын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал” зэргийг баримтлан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлсийг цуглуулах, нягтлан шалгах, ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, баримтад дурдсан мэдээлэлд шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийж, үр дүнг тооцох арга зүйг ашиглав.

Хөвсгөл аймгийн ТЭЗ-д эрх шилжиж ирсэн улсын төсвийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт хийсэн судалгаа, шинжилгээний баримт материал, ажлын тайлан, төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэл болон гэрээний хэрэгжилтэд төрийн захиргааны байгууллага, аймгийн Засаг дарга, түүний харьяа

байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан, болон төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд үндэслэн аудитын дүгнэлт, шийдвэрийг боловсруулсан болно.

Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн нийцлийн газрын даргын 2024.04.08-ны өдрийн 08/921 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийг баримтлан ажилласан болно.

Аудитын багийн бүрэлдэхүүн хугацаа:

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хянан удирдаж, аудитын менежер Б.Тэгшдэлгэр аудитын үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор З.Даваадорж, аудитор Н.Гүрбазар нар аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл:

Монгол улсын 2023 оны Төсвийн тухай хууль 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр батлагдсан ба хуульд 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр өөрчлөлт оруулсан байна.

Нэмэлт өөрчлөлтөөр 2023 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар баталсан улсын төсвийн хөрөнгө оруулалтыг өөрчлөн найруулсан бөгөөд Хөвсгөл аймагт улсын төсвөөс **298,906.4** сая төгрөгийн төсөвт өртөгтэй 74 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, санхүүжүүлэхээр баталсан байна. Үүнээс 22,546.8/2023 оны төсвийн тухай хуулиар/ сая төгрөгийн төсөвт өртөгтэй 18 төсөл, арга хэмжээг Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн байна.

Эрх шилжсэн хөрөнгө оруулалтуудын санхүүжилтэд 2023 онд **5,105.6** сая төгрөг олгохоор батлагдсанаас **4,757.2** сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Тайлант онд олгохоор баталсан санхүүжилтийг хөрөнгө оруулалтын төрлөөр нь ангилан харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №1

Хөрөнгө оруулалтын төрөл	Тоо	2023 оны санхүүжилт	2023 оны санхүүжилтэд эзлэх хувь
Барилга, байгууламж	14	4,649.8	91%
Тоног төхөөрөмж	3	254.9	5%
ТЭЗҮ	1	200.9	4%
Дүн	18	5,105.6	100%

Тайлант онд эрх шилжсэн хөрөнгө оруулалтын санхүүжилт авсан хэмжээг салбараар ангилан, графикаар харуулбал дараах байдалтай байна.

График №1



Шинээр 2023 онд хэрэгжсэн 511.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээнд нээлттэй тендер шалгаруулалтыг зохион байгуулж 11.6 сая төгрөгийн тендерийн хэмнэлт гаргасан байна.

БҮЛЭГ А:

ХАРЬАЛАХ ЯАМД ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВТ ӨРТӨГ, САНХҮҮЖИХ ДҮНГ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТООЦООГҮЙ БАЙНА.

А.1. Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцээгүй төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.

Тайлант онд Засгийн газар болон төсвийн ерөнхийлөн захирагчдаас эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн 18 төсөл арга хэмжээний 22,035.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 17 төсөл арга хэмжээ буюу 97.7 хувь нь өмнөх оноос шилжсэн хөрөнгө оруулалт бол 511.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл арга хэмжээ буюу 2.3 хувь нь шинээр хэрэгжих хөрөнгө оруулалт байна.

Шинээр хэрэгжүүлсэн Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр - Жаргалант сумын Цэцүүх, Цагаанбургас багуудад баригдах Багийн төвийн барилга төсөл, арга хэмжээг аймгийн Засаг даргын хөрөнгө оруулалтын саналд үндэслээгүй, магадлалаар баталгаажсан зураг, төсөвгүй, Төрийн хэмнэлтийн тухай хууль, хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд нийцүүлэн төлөвлөөгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 29^{1.2.2}¹, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.4² дэх тус тус заалтуудыг зөрчсөн байна.

А.2. Өмнөх оноос үргэлжлэн хэрэгжиж буй 4 төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 299.1 сая төгрөгөөр зөрүүтэй тооцсон байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр эрх шилжүүлэн хэрэгжүүлэх 1 төсөл, арга хэмжээнд 511.3 сая төгрөг, 11 төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтэд 1,491.0 сая төгрөг, 11 төсөл, арга хэмжээний барилгын материалын үнийн өсөлтийн зөрүүд 3,103.3 сая төгрөг нийт 5,105.6 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталсан байна. *Үлдэгдэл санхүүжилт, барилгын материалын үнийн зөрүү авахаар батлагдсан төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралт № 1-ээр үзүүлэв/*

Санхүүжилтийг төлөвлөхдөө орон нутгийн оролцоогүйгээр харьяалах яамд дээр төлөвлөн, батлуулсан байна.

Аудитаар төсөл, арга хэмжээний тухайн онд олгох санхүүжилт, төсөвт өртгийг үндэслэлгүй тооцсон дараах зөрчлүүд илэрч байна. **Үүнд:**

1. Баянзүрх сумын Ахмадын төвийн барилгын ажилд материалын үнийн зөрүү тооцоогүй, гэрээний үнийн дүн өөрчлөгдөөгүй байхад **117.3** сая төгрөгийн нэмэлт санхүүжилт баталсан.
2. Ренчинлхүмбэ сумын Цойцон нуурыг нөхөн сэргээх төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт болон материалын үнийн зөрүүнд 139.1 сая төгрөгийн санхүүжилт олгохоор байхад 2023 оны Төсвийн тухай хуульд санхүүжих дүнг 316.9 сая гэж тусган санхүүжих дүнг үндэслэлгүй **177.8** сая төгрөгөөр илүү тооцож баталсан.
3. Засаг даргын Тамгын газрын барилга /Хөвсгөл, Цагаан-Үүр сум/ төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 2023 оны төсвийн тухай хуульд дутуу тооцсоноос **3.7** сая төгрөгийн санхүүжилт олгогдоогүй.
4. Жижиг, дунд оврын усалгааны систем /Хөвсгөл, Галт, Бүрэнтогтох, Тосонцэнгэл, Рашаант, Эрдэнэбулган, Түнэл, Жаргалант сум/ төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтийг 0.3 сая төгрөгөөр илүү тооцсон,

Төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг үндэслэлгүй тооцсоноос 3.7 сая төгрөгийн санхүүжилт олгогдоогүй, дараа онд шилжих өглөг болж, 295.4 сая төгрөгийн санхүүжилтийг өөр төсөл, арга хэмжээнд зарцуулах боломжгүй нөхцөл үүссэн байна.

¹ Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх: барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх;

² Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно: багийн төв, хорооны засаг захиргааны зориулалттай барилга барих, тохижуулах, засварлах, тоног төхөөрөмж худалдан авах;

Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.3.3³ дахь заалтад нийцээгүй байна.

Улсын Их Хурлын 2022 оны 88 дугаар тогтоолын дагуу материалын үнийн зөрүү тооцохдоо 2020 онд улсын комисс ажиллаж ашиглалтад хүлээж авсан 90.8 сая төгрөгийн дараах төсөл, арга хэмжээнүүдэд зөрүү тооцсон байна. Үүнд:

1. “Төрөлх Мөрөн” ХХК-ийн гүйцэтгэсэн Гэр хорооллын хэсэгчилсэн инженерийн хангамжтай жишиг гудамж төсөл /Хөвсгөл, Мөрөн сум/ төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд 2020 оны 12 дугаар 14-ний өдөр Улсын комисс ажиллаж УҚД-2020/84, УҚД-2020/85 тоот актуудаар хүлээж авсан байхад 2021 оны гүйцэтгэлд үнийн өсөлтийн зөрүү тооцон **53.8** сая төгрөг олгохоор баталсан.
2. “Хөвсгөл Эх” ХХК-ийн гүйцэтгэсэн Ахмадын өргөөний барилга /Хөвсгөл, Мөрөн сум, 10, 11, 12, 13, 14 дүгээр баг/ төсөл, арга хэмжээний 2 барилгыг 2020 онд улсын комисс ажиллан УҚД-2020/46, УҚД-2020/71 тоот актуудаар барилгыг хүлээн авсан байхад 2021 оны төсвийн гүйцэтгэлд үнийн өсөлтийн зөрүү тооцон **37.0** сая төгрөг олгохоор баталсан.

Дээрх зөрчил нь Барилга хот байгуулалтын сайдын 2022 оны 75 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих барилга байгууламжийн төсөвт өртгийн /барилгын материалын үнэ/ өөрчлөлтийг тооцох түр журам”-ын 2.1⁴ дэх заалтад нийцээгүй байна.

Өмнөх оноос хэрэгжиж буй 4 төсөл, арга хэмжээний төсөв, өртөг, санхүүжих дүнг 299.1 сая төгрөгөөр зөрүүтэй тооцсон, 2020 онд хэрэгжиж ашиглалтад хүлээн авсан 90.8 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээнд материалын үнийн зөрүү тооцож 2023 оны төсвийн хуульд батлуулсан зэргээс үзэхэд харьяалах яам/ТЭЗ/-д нь төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг үндэслэлтэй тооцоогүй байна.

А.3. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон байна.

Эрх шилжсэн хөрөнгө оруулалтуудын санхүүжилтэд 2023 онд **5,105.6** сая төгрөг олгохоор батлагдсанаас **4,757.2** сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Үүнээс **946.8** сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн байна.

Олгогдоогүй санхүүжилтийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт № 2

№	Төсөл, арга хэмжээний нэр	Мөнгөн дүн /сая төгрөг/	Санхүүжилт олгоогүй шалтгаан
1	Жижиг, дунд оврын усалгааны систем /Хөвсгөл, Галт, Бүрэнтогтох, Тосонцэнгэл, Рашаант, Эрдэнэбулган, Түнэл, Жаргалант сум/	0.3	Санхүүжилтийн дүнг илүү тооцон тул олгогдоогүй
2	Дархадын хотгорын цөлжилтийг бууруулах, Цойцон нуурыг нөхөн сэргээх /Хөвсгөл, Ренчинлхүмбэ сум/	177.8	Санхүүжилт үндэслэлгүй тооцсон тул олгогдоогүй
3	Ахмадын төвийн барилга /Хөвсгөл, Баянзүрх, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сум/ - багц 1 - Баянзүрх сумын Ахмадын төвийн барилга	117.3	Санхүүжилт үндэслэлгүй тооцсон тул олгогдоогүй
4	Бэлчээрийн усан хангамж /Хөвсгөл, Түнэл, Тосонцэнгэл, Рашаант, Бүрэнтогтох, Их-Уул, Төмөрбулаг, сум/	35.3	Их-Уул суман дахь худгаас ус гараагүй тул 1 худгийн ажлын санхүүжилт магадалшгүй ажлын зардлыг олгоогүй
5	Засаг даргын Тамгын газрын барилга /Хөвсгөл, Цагаан-Үүр сум/	3.7	Төсвийн тухай хуульд гэрээний үнийн дүн буюу төсөвт өртгийг буруу тооцон тусгасан тул санхүүжилт олгох боломжгүй болсон.
6	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл/ Жаргалант сумын Цэцүүх, Цагаан-бургас багуудад багийн төвийн барилга барих	11.6	Тендерийн хэмнэлт

³ Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний санхүүжилт нь гэрээ, төслийн үе шатны хуваарь, санхүүжилтийн төлөвлөгөөтэй уялдаж, нийцсэн байна;

⁴ Энэ журмаар хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс өмнө төсөл, арга хэмжээг гүйцэтгэх гэрээг байгуулсан бөгөөд 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойших үлдэгдэл ажилд материалын үнийн дундаж өсөлтөөр тооцоход хамаарна.

7	Хэрээтийн даваа, Бийжийн даваа, Бор бургасны давааны зам засварын зураг төсөв /Хөвсгөл, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сум/	2.3	Алданги
	Нийт	348.3	

Аудитаар хөрөнгө оруулалтын санхүүжилтэд хяналт хийхэд “Тэмээн”ХХК-ийн гүйцэтгэж буй Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сумдын Ахмадын төвийн барилгын салхивчийн ажил, гадна цахилгаан хангамж – 0.4 кв-ын кабелийн шугамын ажил, 0.4 кв-ын агаарын шугамын ажил, гадна гэрэлтүүлгийн ажил, ариутгах татуургын гадна шугамын ажил, бохир усны цооногийн ажил /V=10м3/ гэх мэт ажлууд хийгдээгүй байхад 181.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Дээрх төсөл, арга хэмжээ нь одоог хүртэл ашиглалтад ороогүй байгаа тул гүйцэтгэгчээр ажлыг гүйцэтгүүлж, хугацаа хоцорсон зөрчилд гэрээний хариуцлага тооцож ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжин хэрэгжсэн төсөл, арга хэмжээг орон нутгийн хэрэгцээ шаардлагад үндэслээгүй, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон Төсвийн тухай хуульд нийцүүлэн төлөвлөөгүй, харьяалах яамд өмнөх оноос үргэлжлэн хэрэгжсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг үндэслэлтэй тооцоогүй байна.

БҮЛЭГ Б:

ГҮЙЦЭТГЭГЧ ГЭРЭЭНД ЗААСАН АЖЛЫГ ХУГАЦААНД ГҮЙЦЭТГЭЭГҮЙ, ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙГААГААС ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ ТӨЛӨВЛӨСӨН ҮР ДҮНД ХҮРЭХГҮЙ БАЙНА.

Б.1. Зарим төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд нь, холбогдох зураг төсөв, техникийн шаардлагын дагуу хэрэгжүүлээгүй байна.

Тайлант онд 15,799.0 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээ ажлын гүйцэтгэл гаргаж хэрэгжсэнээс 11,380.5 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээг ашиглалтад хүлээж авсан байна.

Хөвсгөл аймгийн хувьд төсвийн хөрөнгө оруулалтын барилга байгууламжийн ажилд Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв, бусад ажилд аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг хяналтыг хэрэгжүүлж байна.

Барилга байгууламжийн ажлыг ашиглалтад хүлээн авахын өмнө захиалагчийн хяналтын төвөөс улсын комисс ажиллуулах эсэх талаар дүгнэлт гаргасны үндсэн дээр улсын комисс ажиллаж хяналт хийн, ашиглалтад хүлээн авч ажиллажээ.

Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд хяналт хийхэд хугацаандаа гүйцэтгэгдээгүй болон зураг төсөв, техникийн шаардлагын дагуу хийгдээгүй дараах асуудлууд илэрч байна. Үүнд:

Хугацааны хувьд:

1. Төрөлх Мөрөн ХХК-ийн гүйцэтгэж буй Нийтийн халуун усны барилга /Хөвсгөл, Баянзүрх, Алаг-Эрдэнэ сум/ төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хянахад тус арга хэмжээг 2023 оны 07 дугаар сарын 08-ны өдөр хэрэгжиж дуусгах ёстой байсан боловч одоогийн байдлаар Алаг-Эрдэнэ сумын халуун усны барилгын ажлын гүйцэтгэл 34, Баянзүрх сумын халуун усны барилгын ажлын гүйцэтгэл 20 хувьтай байна.



Зураг 1. Алаг-Эрдэнэ сумын Нийтийн халуун усны барилга



Зураг 2. Баянзүрх сумын Нийтийн халуун усны барилга

2. Анубулаг ХХК, Тэмээн ХХК нарын гүйцэтгэж буй Ахмадын төвийн барилга /Хөвсгөл, Баянзүрх, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сум/ төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хянахад тус арга хэмжээг 2023 оны 12 дугаар сарын 30-ны өдөр хэрэгжиж дуусах ёстой байсан боловч гүйцэтгэгчээс шалтгаалан одоогийн байдлаар Баянзүрх сумын барилгын ажлын гүйцэтгэл 20, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сумдын барилгын ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна.



Зураг 3. Баянзүрх, Чандмань-Өндөр, Цагаан-Үүр сумдын Ахмадын төвийн барилга

Зураг, төсөв, техникийн шаардлагын хувьд:

1. Ахмадын төвийн барилга /Хөвсгөл, Баянзүрх, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сум/ төсөл, арга хэмжээний хүрээнд Чандмань-Өндөр сумдад баригдсан Ахмадын төвийн барилгын ажлыг техникийн дагуу гүйцэтгээгүй, шат, суурийн хаяавчинд хагарал өгсөн байдалтай байна.




Зураг 4. Чандмань-Өндөр сумын Ахмадын төвийн барилгын суурь, шатны ажлын зураг

2. Чандмань-Өндөр, Цагаан-Үүр сумдын Ахмадын төвийн барилгын ханыг зурагт зааснаас 60 см-ээр намхан хийсэн байна. Иймд 60 см баригдаагүй ханын ажлын материалын үнэ 6.7 сая төгрөгт төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.



Зураг 5. Чандмань-Өндөр, Цагаан-Үүр, Баянзүрх сумдын Ахмадын төвийн барилгын ханын ажлын зураг

3. Цагаан-Үүр сумын Засаг даргын Тамгын газрын барилгын агааржуулалтын ажлыг хийхдээ агааржуулалтын хоолойг ил хийсэн, нэг хананд хоолойг хана өрөмдөж гаргасан зэрэг зураг, төсвөөс зөрүүтэй гүйцэтгэсэн байна.



Зураг 6. Цагаан-Үүр сумын ЗДТГ-ын барилгын агааржуулалтын ажлын зураг

4. Төрөлх мөрөн ХХК-ийн гүйцэтгэж буй Баянзүрх сумын нийтийн халуун усны барилгын ажлыг зураг, төсөвт туссанаар 15х15 см харьцаатай балк модоор барих ёстой байтал гүйцэтгэлээр 12х15 см харьцаатай балк модоор барьсан байна. Зөрчилд материалын үнийн зөрүү тооцох албан шаардлагыг Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ААТҮГ-т хүргүүлэхээр шийдвэрлэв.



Зураг 7. Баянзүрх сумын Нийтийн халуун усны барилгын ханын ажлын зураг

Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ААТҮГ нь дээрх төсөл, арга хэмжээнүүдэд хэрэгжиж эхэлсэн үеэс нь хойш гүйцэтгэлийн үе шатны хяналт хэрэгжүүлж ажилласан ч дээрх ажлуудыг гэрээнд заасан хугацаа, зураг, төсөв, техникийн шаардлагын дагуу гүйцэтгүүлээгүй байна.

Эрх шилжсэн хөрөнгө оруулалтын 2 төсөл, арга хэмжээ гэрээнд заасан хугацаанд дуусаагүй, 3 төсөл, арга хэмжээний барилгын ажлыг зураг төсөв, техникийн шаардлагын дагуу гүйцэтгээгүй байгаа зэргээс үндэслэн гүйцэтгэгч нь төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд нь, холбогдох зураг төсөв, техникийн шаардлагын дагуу хэрэгжүүлээгүй, барилга захиалагчийн хяналтын төв нь гэрээний хугацаа, ажлын гүйцэтгэлд хангалтгүй хяналт хийсэн байна гэж дүгнэлээ.

Б.2. Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс нь хяналтын чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтад хийсэн хяналтын үр дүнд 2 төсөл, арга хэмжээний 37.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгоогүй эерэг үр дүн гаргаж ажилласан боловч дараах төсөл, арга хэмжээнүүдэд ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс захиалагчийн чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. Аймаг, сумын ЗДТГ-ын тоног төхөөрөмж /Хөвсгөл/ төсөл, арга хэмжээний санхүүжилтийг 2022 онд татуулсны улмаас 2023 онд санхүүжилт олгохдоо гэрээний үүргийн дагуу Ай Ти Зон ХХК-д 8.9 сая төгрөгийн алданги төлсөн байна. Төсөв татагдсан дээрх тохиолдолд захиалагчийн зүгээс гэрээний хугацааг сунгах, тохиролцох талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.
2. Өмнөх онд хэрэгжсэн Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл, Жаргалант, Галт, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Их-Уул, Рашаант сум/ төсөл, арга хэмжээ (Багц-1 Хүнсний зориулалттай модон сав худалдан авах ажил)-д Төрөлх Мөрөн ХХК гүйцэтгэгчээр шалгарч гэрээ байгуулсан боловч одоог хүртэл тухайн ажлыг гүйцэтгээгүй, санхүүжилт 67.7 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.
3. Өмнөх онд Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр төсөл, арга хэмжээний Багц-2 сэрээт өргөгч худалдан авах ажилд Төрөлх Мөрөн ХХК гүйцэтгэгчээр шалгарч гэрээ байгуулсан боловч одоог хүртэл ажлыг гүйцэтгээгүй, санхүүжилт 40.0 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

Хөрөнгө оруулалтад хяналт хийх чиг үүрэг бүхий аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба, ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс хяналт хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Б.3. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгэх шийдвэр ирүүлээгүй тул 16,861.0 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

Тайлант оны жилийн эцсийн байдлаар ашиглалтад хүлээн авсан 18,128.4 сая төгрөгийн 15 төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгөөс 837.4 сая төгрөгийн барилга байгууламж, 430.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж зэрэг нийт 1,267.4 сая төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгасан байна. *Нягтлан бодох бүртгэлд тусгасан болон тусгаагүй төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралт № 3-оор харуулав.*

Нягтлан бодох бүртгэлд тусгаагүй 16,861.0 сая төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгах саналыг Орон нутгийн өмчийн газраас Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлж ажиллаагүй байна.

Ашиглалтад хүлээн авсан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг бүртгүүлэх саналыг 2024 онд багтаан эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэр гаргуулах ажлыг аймгийн орон нутгийн өмчийн газраас зохион байгуулах зөвлөмжийг хүргүүллээ.

Аудитаар өмнөх онуудад хэрэгжсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтын өмч бүртгэлтэй холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Хөвсгөл аймгийн ЗДТГ-т бүртгэлтэй 94.1 сая төгрөгийн 20 ширхэг "Жижиг, дунд оврын усалгааны систем"-ийг ямар нэгэн шийдвэргүйгээр Галт, Бүрэнтогтох, Тосонцэнгэл, Рашаант, Эрдэнэбулган, Түнэл, Жаргалант сумдад шилжүүлсэн.
- Эрх шилжээгүй хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжсэн "Орон нутгийг дэмжих "Шинэ хөдөө" улсын хэмжээнд" төсөл арга хэмжээний хүрээнд нийлүүлэгдэх 103.3 сая төгрөгийн 7 ширхэг "барша помп" усалгааны системийг биетээр хүлээж аваагүй байхад аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын 2022 оны А/90 дүгээр тушаалаар Бүрэнтогтох, Тосонцэнгэл, Түнэл, Рашаант сумдад хуваарилж бүртгэхээр шийдвэрлэсэн байна.

Тухайн тоног төхөөрөмжийг тушаал шийдвэрийн дагуу холбогдох байгууллагуудад нь хуваарилах, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтанд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Зарим төсөл, арга хэмжээнүүдийг гүйцэтгэгч гэрээнд заасан хугацаа, зураг төсөв, техникийн шаардлагын дагуу гүйцэтгээгүй, захиалагч нь хяналтын чиг үүргээ хангалттай хэрэгжүүлээгүй, ашиглалтад хүлээн авсан 16,861.0 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг нягтлан

бодох бүртгэлд тусгаагүй байгаа нь хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд сөрөг нөлөө үзүүлж байна.

БҮЛЭГ В:	УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БИЙ БОЛСОН ХӨРӨНГИЙГ ТҮРЭЭСЛҮҮЛЭН ОЛСОН 301.5 САЯ ТӨГРӨГИЙГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УРСГАЛ ЗАРДАЛД ЗАРЦУУЛЖ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ӨГӨӨЖИЙГ БУУРУУЛЖ БАЙНА.
-----------------	---

В.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн ашиглалт хангалтгүй зарим төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг одоог хүртэл ашиглаагүй, түрээсийн орлогыг үйл ажиллагааны зардалд зарцуулж байгаа нь төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020-2023 онуудад эрх шилжин хэрэгжсэн 18,133.9 сая төгрөгийн 15 төсөл, арга хэмжээний хөрөнгийг ашиглалтад хүлээн авсан байна. Дээрх 15 төсөл, арга хэмжээнээс 10,193.6 сая төгрөгийн 11 төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж байгаа бол 8,014.7 сая төгрөгийн 4 төсөл, арга хүрээнд бий болсон хөрөнгүүдийг ашиглаж эхлээгүй байна. Ашиглаж эхэлсэн болон ашиглахгүй байгаа төсөл, арга хэмжээг хувиар илэрхийлбэл дараах байдалтай байна. /график №1/




График №1

Хөрөнгийн ашиглалтыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт № 3

	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Ашиглалтын байдал
1	Засаг даргын Тамгын газрын барилга /Хөвсгөл, Цагаан-Үүр сум/	1,588.2	Зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж байна.
2	Засаг даргын Тамгын газрын барилга /Хөвсгөл, Түнэл сум/	2,279.7	Зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж байна.
3	Аймаг, сумын ЗДТГ-ын тоног төхөөрөмж/Хөвсгөл/	50.0	Зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж байна.
4	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр	511.3	Зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж байна.
5	Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж /Хөвсгөл/	294.8	Хүнсний ногоо, даршлах тоног төхөөрөмж болон Тосонцэнгэл сумын ЗДТГ-т олгосон трактор иж бүрдэл 195.6 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг ашиглаж эхлээгүй байна.
6	Жижиг, дунд оврын усалгааны систем /Хөвсгөл, Галт, Бүрэнтогтох, Тосонцэнгэл, Рашаант, Эрдэнэбулган, Түнэл, Жаргалант сум/	100.0	Ашиглаагүй.
7	Бэлчээрийн усан хангамж /Хөвсгөл, Түнэл, Тосонцэнгэл, Рашаант, Бүрэнтогтох, Их-Уул, Төмөрбулаг, сум/	198.3	Зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж байна.
8	Гэр хорооллын хэсэгчилсэн инженерийн хангамжтай жишиг гудамж төсөл /Хөвсгөл, Мөрөн сум/	1,830.3	Зориулалтын дагуу ашиглаж байгаа боловч бүрэн хүчин чадлаар ашиглаагүй байна.
9	Сургуулийн барилга, спорт заал, 320 суудал /Хөвсгөл, Их-Уул сум/	4,853.1	Барилгын халаалт хангалтгүй, ширээ сандал, тавилга хэрэгсэл ирээгүй тул барилгын 10 хувийг ашиглаж байна.
10	Цэцэрлэгийн барилга, 50 ор /Хөвсгөл, Мөрөн сум/	1,201.9	Зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж байна.
11	Дархадын хотгорын цөлжилтийг бууруулах, Цойцон нуурыг нөхөн сэргээх /Хөвсгөл, Ренчинлхүмбэ сум/	1,026.9	Зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж байна.

12	Аялал жуулчлал, мэдээлэл сурталчилгааны "Соёмбо" цогцолборын дэд бүтэц, тохижилт /Хөвсгөл, Мөрөн сум/	837.4	Зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж байна.
13	Ахмадын өргөөний барилга /Хөвсгөл, Мөрөн сум, 10, 11, 12, 13, 14 дүгээр баг/	408.7	Зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж байна.
14	Хэрээтийн даваа, Бийжийн даваа, Бор бургасын давааны зам засварын зураг төсөв /Хөвсгөл, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сум/	260.9	Зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж байна.
15	Сумын төвийн бетон авто зам, 8.3 км /Хөвсгөл, Тариалан сум/ - багц 1 - Төв замаас 2 км бетон зам тавих	2,766.8	Улсын комиссын үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, улирлын чанартай зарим ажлын гүйцэтгэл хийгдээгүй байгаа тул замыг хэсэгчлэн хааж ашиглаж байна.
Нийт		18,133.9	

Өмнөх онуудад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн ашиглалтыг түүвэрлэн шалгахад 314.3 сая төгрөгийн дараах барилга байгууламж, тоног төхөөрөмжийг одоог болтол зориулалтын дагуу ашиглаж эхлээгүй байна. Үүнд:

1. Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төслийн багц-7 ажлын хүрээнд Колортийм ХХК-ийн 2022 онд нийлүүлсэн 148.9 сая төгрөгийн 10 ширхэг ашиглалтын зардал багатай усалгаажуулалтын систем /Барша Помп/-ийг одоог хүртэл ашиглаагүй Хөдөөгийн шийдэл ХХК-ийн агуулахад хадгалж байна.
2. Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төслийн багц-9 ажлын хүрээнд Жемруби ХХК-ийн нийлүүлсэн 25.5 сая төгрөгийн арьс шир боловсруулах 1 иж бүрдэл тоног төхөөрөмжийг одоог хүртэл ашиглаагүй Хөдөөгийн шийдэл ХХК-ийн агуулахад хадгалж байна.
3. Тод горхи ХХК-ийн 2002 онд ашиглалтад хүлээлгэн өгсөн 139.9 сая төгрөгийн өртөгтэй Нийтийн ариун цэврийн байгууламжийг одоог хүртэл ашиглаагүй байна.

Дээрх улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгүүдийг зориулалтын дагуу ашиглах талаар холбогдох албан тушаалтанд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Өмнөх онуудад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл болон Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж /Хөвсгөл/ төсөл, арга хэмжээнүүдийн хүрээнд бий болсон 3,131.3 сая төгрөгийн 677 ширхэг мал, тоног, төхөөрөмжийг хөдөлмөр эрхлэгч болон малчин иргэдэд түрээслэн өмчлүүлэх болон ашиглуулах гэрээний үндсэн дээр эзэмшүүлж, түрээсийн төлбөрийн орлогыг "Хөдөөгийн шийдэл" ХХК-д төвлөрүүлэн, үйл ажиллагаандаа зарцуулж байна. **Тухайлбал:** 2023 онд "Хөдөөгийн шийдэл" ХХК нь 337.1 сая төгрөгийн түрээсийн орлого олж 337.3 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөн, гүйцэтгэлээр түрээсийн орлогод төвлөрсөн 378.3 сая төгрөгөөс 301.5 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.

Энэ нь өмнөх аудитаар өгсөн хөрөнгө оруулалтын ашиглалтын чиглэлийг нарийвчлан тогтоож ашиглах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон мөнгөн хөрөнгө орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагааны зардалд зарцуулагдаж, төсөл үргэлжлэн хэрэгжих санхүүжилтийн эх үүсвэргүй болох нөхцөлийг бий болгож байна. Иймд зөрчлийг арилгах, дээрх хөрөнгөөс орж ирж буй орлогоор хөдөө, аж ахуйн салбарт үргэлжлүүлэн хөрөнгө оруулалт хийж хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн ашиглалт хангалтгүй зарим төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг одоог хүртэл ашиглаагүй, түрээсийн орлогыг үйл ажиллагааны зардалд зарцуулж байгаа нь төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна.

В.2. Эрх шилжсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт 61 хувийн биелэлттэй байна.

Улсын төсвийн эрх шилжсэн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 22,546.9 сая төгрөгийн 18 төсөл, арга хэмжээнээс 15,772.3 сая төгрөгийн 11 төсөл, арга хэмжээ төлөвлөсөн үр дүнд хүрсэн бол 6,904.5 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээ төлөвлөсөн үр

дүнд хүрээгүй, 1,830.3 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээний үр дүн хангалтгүй буюу хөрөнгө оруулалтын үр дүнг үнэлэхэд 61 хувьтай байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүд төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэхийг хүснэгтээр харуулбал дараах дүнтэй байна.

Хүснэгт № 4

	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх	Төлөвлөсөн үр дүнд хүрсэн сэх
1	Засаг даргын Тамгын газрын барилга /Хөвсгөл, Цагаан-Үүр сум/	1,588.2	Тийм	Цагаан-Үүр сумын ЗДТГ-ын барилга нь хуучирч, муудсан байсан тул төрийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах төлөвлөсөн үр дүнд хүрсэн
2	Засаг даргын Тамгын газрын барилга /Хөвсгөл, Түнэл сум/	2,279.7	Тийм	Цагаан-Үүр сумын ЗДТГ-ын барилга нь хуучирч, муудсан байсан тул төрийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах төлөвлөсөн үр дүнд хүрсэн
3	Аймаг, сумын ЗДТГ-ын тоног төхөөрөмж/Хөвсгөл/	50.0	Тийм	Аймаг, сумын ЗДТГ-ын 25 төрийн албан хаагч компьютер, дэлгэцээр хангагдсан техникийн шинэчлэл хийгдсэн тул төлөвлөсөн үр дүнд хүрсэн.
4	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр	511.3	Тийм	Жаргалант сумын Цэцүүх, Цагаанбургас багууд Багийн төвийн барилгатай болгох төлөвлөсөн үр дүнд хүрсэн
5	Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж /Хөвсгөл/	294.8	Үгүй	Төсөл, арга хэмжээ нь хэрэгжиж дууссан боловч худалдан авсан тоног, төхөөрөмжийг ашиглаж эхлээгүй тул төлөвлөсөн үр дүнд хүрээгүй
6	Жижиг, дунд оврын усалгааны систем /Хөвсгөл, Галт, Бүрэнтогтох, Тосонцэнгэл, Рашаант, Эрдэнэбулган, Түнэл, Жаргалант сум/	100.0	Үгүй	Төсөл, арга хэмжээ нь хэрэгжиж дууссан боловч худалдан авсан тоног, төхөөрөмжийг ашиглаж эхлээгүй тул төлөвлөсөн үр дүнд хүрээгүй
7	Бэлчээрийн усан хангамж /Хөвсгөл, Түнэл, Тосонцэнгэл, Рашаант, Бүрэнтогтох, Их-Уул, Төмөрбулаг, сум/	198.3	Тийм	Хөвсгөл аймгийн Түнэл, Рашаант, Тосонцэнгэл, Төмөрбулаг, Бүрэнтогтох сумдад нэг нэг нийт 5 гүний автомат ажиллагаатай худагтай болж ашиглагдаж байгаа тул төлөвлөсөн үр дүнд хүрсэн
8	Гэр хорооллын хэсэгчилсэн инженерийн хангамжтай жишиг гудамж төсөл /Хөвсгөл, Мөрөн сум/	1,830.3	Үгүй	50 айлын дулаан, цэвэр, бохир усаар хангах хүчин чадалтай дэд бүтцийн системд 36 айл холбогдсон тул төлөвлөсөн үр дүн хангалтгүй байна.
9	Нийтийн халуун усны барилга /Хөвсгөл, Баянзүрх, Алаг-Эрдэнэ сум/	648.3	Үгүй	Төсөл, арга хэмжээ хэрэгжиж дуусаагүй тул Баянзүрх, Алаг-Эрдэнэ сумдын төвийн иргэдийг нийтийн халуун устай болгох төлөвлөсөн үр дүнд хүрээгүй
10	Сургуулийн барилга, спорт заал, 320 суудал /Хөвсгөл, Их-Уул сум/	4,853.1	Тийм	Их-Уул сумын сургуулийн барилгыг шинэчлэх, боловсролын орчныг сайжруулах төлөвлөсөн үр дүнд хүрсэн
11	Цэцэрлэгийн барилга, 50 ор /Хөвсгөл, Мөрөн сум/	1,201.9	Тийм	Төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтийг орон нутгийн төсвөөс олгосон ба үүн дээр нэмэлт санхүүжилт олгосон нь төсөл, арга хэмжээг бүрэн дуусгахад дэмжлэг үзүүлэх төлөвлөсөн үр дүнд хүрсэн.
12	Дархадын хотгорын цөлжилтийг бууруулах, Цойцон нуурыг нөхөн сэргээх /Хөвсгөл, Ренчинлхүмбэ сум/	1,026.9	Тийм	Голын эвдэрсэн голдирлыг өөрчилж Цойцон нуурыг нөхөн сэргээсэн тул төсөл, арга хэмжээ төлөвлөсөн үр дүнд хүрсэн.
13	Аялал жуулчлал, мэдээлэл сурталчилгааны "Соёмбо" цогцолборын дэд бүтэц, тохижилт /Хөвсгөл, Мөрөн сум/	837.4	Тийм	Соёмбо цогцолбор нь аяллын улиралд аялагч, жуулчдын байнга саатдаг цэг болсон тул төлөвлөсөн үр дүнд хүрсэн.
14	"Соёмбо" цэцэрлэгт хүрээлэн /Хөвсгөл, Мөрөн сум/	2,294.0	Үгүй	Хэрэгжиж дуусаагүй тул төлөвлөсөн үр дүнд хүрээгүй
15	Ахмадын өргөөний барилга /Хөвсгөл, Мөрөн сум, 10, 11, 12, 13, 14 дүгээр баг/	408.7	Тийм	Төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон барилгыг багийн Засаг дарга, ахмадууд хамтран ашиглаж байгаа тул төлөвлөсөн үр дүнд хүрсэн

16	Ахмадын төвийн барилга /Хөвсгөл, Баянзүрх, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сум/	1,476.2	Үгүй	Хэрэгжиж дуусаагүй тул төлөвлөсөн үр дүнд хүрээгүй
17	Хэрээтийн даваа, Бийжийн даваа, Бор бургасын давааны зам засварын зураг төсөв /Хөвсгөл, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сум/	260.9	Үгүй	Хэрээтийн даваа, Бийжийн даваа, Бор бургасын давааны зам засварын ажил одоог хүртэл хийгдээгүй, төсөв хуучирсан тул төлөвлөсөн үр дүнд хүрээгүй
18	Сумын төвийн бетон авто зам, 8.3 км /Хөвсгөл, Тариалан сум/ - багц 1 - Төв замаас 2 км бетон зам тавих	2,766.8	Тийм	Улаанбаатар-Мөрөн чиглэлийн төв замаас Тариалан сум хүртэл 2 км зам тавигдсан тул төлөвлөсөн үр дүн хүрсэн
Нийт		22,546.9		

Хөрөнгө оруулалтын санхүүжилт гүйцэтгэлийн талаарх мэдээллийг publicinvestment.gov.mn, shilendans.gov.mn цахим сайтуудад тогтмол оруулж ажилласан байна

В.4 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн биелүүлээгүйгээс зөрчил давтагдан гарсан байна.

Төрийн аудитын газраас 2023 онд гүйцэтгэсэн аудитаар 2 албан шаардлага, 8 албан тушаалтанд нийт 11 зөвлөмж хүргүүлсэн. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага бүрэн биелсэн бол зөвлөмжийн хэрэгжилтийг тооцож үзэхэд хэрэгжсэн 5, хэрэгжээгүй 6 буюу хэрэгжилт 45.5%-тай байна. Дараах зөвлөмжүүд хэрэгжээгүй зөрчил дахин давтагдсан байна. **Үүнд:**

- Төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хүлээн авсан боловч одоо болтол зориулалтын дагуу хэрхэн ашиглах нь тодорхойгүй, холбогдох байгууллагын бүртгэлд байгаа барилга байгууламж, тоног төхөөрөмжийн ашиглалтын чиглэлийг нарийвчлан тогтоож, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлэх;
- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний санхүүжилтийг олгох, хянах албан хаагчдад хяналт, хариуцлагыг сайжруулах;
- Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах, гэрээний заалтыг биелүүлээгүй аж ахуйн нэгжид гэрээнд заасан хариуцлагын арга хэмжээг авах;
- Техникийн нэр зөрүүтэй гаргасан тушаал болон холбогдох байгууллагуудад бүртгэсэн хөрөнгийн нэршлийг өөрчилж алдааг залруулан, эд хөрөнгийг хүлээн авагч байгууллага бодитоор хүлээн авсан үед үндсэн хөрөнгөд бүртгүүлж байх;
- Төсвийн хөрөнгө оруулалтад аудит хийж, үр дүнг сайжруулж ажиллах;
- Төсвийн хөрөнгө оруулалтад хяналт хийж үнэлгээ өгч ажиллах;

Зөвлөмж хэрэгжүүлээгүй албан хаагчдад зөрчил арилгах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Аудитаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээнд хийх хяналтын үр дүн хангалтгүй, хөрөнгийг зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар нь ашиглаагүй зэрэг зөрчил давтагдан гарч байгаа нь өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн биелүүлээгүйг харуулж байна.

Улсын төсвийн эрх шилжсэн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгүүдийн ашиглалт 73 хувьтай, төлөвлөсөн үр дүнгийн биелэлт 61 хувьтай байгаагаас дүгнэвэл хөрөнгийн ашиглалт хангалтгүй, төлөвлөсөн үр дүнд бүрэн хүрээгүй байна.

Аудитаар нийт 1,000.5 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 6.7 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 496.2 сая төгрөгийн 8 албан шаардлага, 107.7 сая төгрөгийн 8 зөвлөмжийг 8 байгууллага, албан тушаалтанд өгч ажиллалаа.

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжин хэрэгжсэн төсөл, арга хэмжээг орон нутгийн хэрэгцээ шаардлагад үндэслээгүй, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон Төсвийн тухай хуульд нийцүүлэн төлөвлөөгүй, харьяалах яамд өмнөх оноос үргэлжлэн хэрэгжсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг үндэслэлтэй тооцоогүй байна.
2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг түрээслүүлэн олсон 301.5 сая төгрөгийг үйл ажиллагааны урсгал зардалд зарцуулж хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна.
3. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгэх шийдвэр ирүүлээгүй тул 16,861.0 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээний хүрээнд бий хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байгаа нь хөрөнгө оруулалтын хүрээнд бий болсон хөрөнгийн үнэ цэнийг бууруулах, үрэгдэх эрсдэлийг бий болгож байна.
4. Улсын төсвийн эрх шилжсэн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгүүдийн ашиглалт 73 хувьтай, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт 61 хувьтай байгаа нь хөрөнгийн ашиглалт хангалтгүй, төлөвлөсөн үр дүнд бүрэн хүрээгүй болохыг харуулж байна.
5. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээнд хийх захиалагчийн хяналтын үр дүн хангалтгүй, хөрөнгийг зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар нь ашиглаагүй зэрэг зөрчил давтагдан гарах нөхцөл болж байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Г.Мөнгөнхуягт:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгүүдийн ашиглалтыг сайжруулж, үр өгөөжийг нэмэгдүүлэх.

Аймгийн Засаг дарга П.Лхагважавт:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгүүдийг нягтлан бодох бүртгэлд тусгах ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах;
2. Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Барилга захиалагчийн хяналтын төв ААТҮГ, Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба, Хяналт, шинжилгээ-үнэлгээний хэлтэс зэрэг хяналтын чиг үүрэг бүхий байгууллагуудын хяналтын үр нөлөөг сайжруулах арга хэмжээ авах

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батбилгүүнд:

1. Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлж ажиллах;

Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Цэнд-Аюушид:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгах ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах үр өгөөжийг сайжруулах;

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Оюунтуяад:

1. Хяналтын чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж гүйцэтгэгчээс гэрээний үүргээ биелүүлэхийг шаардах, төрийн зүгээс гэрээний хариуцлага хүлээх нөхцөл байдал үүссэн үед арга хэмжээ авч ажиллах;
2. Өмнөх онд Төрөлх Мөрөн ХХК гүйцэтгэгчээр шалгарч гэрээ байгуулсан, санхүүжилт 107.7 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээний гэрээний үүргийн биелэлтийг хангуулах.

Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ААТҮГ-ын захирал Х.Даваасүрэнд:

1. Зураг, төсөв, техникийн шаардлагын дагуу гүйцэтгээгүй ажлуудын зөрчлийг арилгуулах, захиалагчийн хяналтын үр нөлөөг сайжруулах

Зөрчлийн жагсаалт:

№	Илэрсэн зөрчлийн		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Утга	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тайлант онд шинээр хэрэгжсэн Жаргалант сумын Цэцүүх, Цагаанбургас багуудад баригдсан Багийн төвийн барилга төсөл, арга хэмжээг Төсвийн тухай болон Төрийн хэмнэлтийн хуульд нийцүүлэн төлөвлөөгүй байна.	-						
2	Өмнөх оноос үргэлжлэн хэрэгжиж буй 4 төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 299.1 сая төгрөгөөр зөрүүтэй тооцсон	299.1						
3	Улсын Их Хурлын 2022 оны 88 дугаар тогтоолын дагуу материалын үнийн зөрүү тооцохдоо тогтоолын үйлчлэлд хамаарахгүй 2020 онд улсын комисс ажиллаж ашиглалтад хүлээж авсан 90.8 сая төгрөгийн дараах төсөл, арга хэмжээнүүдэд зөрүү тооцсон байна.	90.8						
4	Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сумдын Ахмадын төвийн барилгын салхивчийн ажил, Гадна цахилгаан хангамж – 0.4кв-ын кабелийн шугамын ажил, 0.4кв-ын агаарын шугамын ажил, гадна гэрэлтүүлгийн ажил, ариутгах татуургын гадна шугамын ажил, бохир усны цооногийн ажил /V=10м3/ гэх мэт ажлууд хийгдээгүй байхад 181.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон.	181.9			1	181.9		
5	Баянзүрх, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сумдын Ахмадын өргөөний барилгын ажлууд гэрээнд заасны дагуу 2023 оны 12 дугаар сарын 30-ны өдөр хэрэгжиж дуусах ёстой байсан боловч гүйцэтгэгчээс шалтгаалан 2023 онд хэрэгжиж дуусаагүй Баянзүрх сумын барилгын ажлын гүйцэтгэл 20, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сумдын барилгын ажлын гүйцэтгэл 80 хувийн гүйцэтгэлтэй байна.							
6	Чандмань-Өндөр сумдад баригдсан Ахмадын төвийн барилгын ажлыг техникийн дагуу гүйцэтгэгдээгүйгээс суулт үүсэж, шат, суурийн хөвөөнд цууралт өгсөн байна. (зөрчлийг арилгах, хяналт хийж ажиллах)							
7	Баянзүрх, Алаг-Эрдэнэ сумдын Нийтийн халуун усны барилга гэрээний дагуу 2023 оны 07 дугаар сарын 08-ны өдөр хэрэгжиж дуусах ёстой байсан боловч гүйцэтгэгчээс шалтгаалан 2023 онд хэрэгжиж дуусаагүй Алаг-Эрдэнэ сумын халуун усны барилгын ажлын гүйцэтгэл 34, Баянзүрх сумын халуун усны барилгын ажлын гүйцэтгэл 20 хувьтай байна.	-			1			
8	Чандмань-Өндөр, Цагаан-Үүр сумдын Ахмадын төвийн барилгын ханыг зурагт зааснаас 60 см-ээр намхан хийсэн байна.	6.7	1	6.7				
9	Цагаан-Үүр сумын Засаг даргын Тамгын газрын барилгын агааржуулалтын ажлыг хийхдээ агааржуулалтын хоолойг ил хийсэн, нэг хананд хоолойг хана өрөмдөж гаргасан зэрэг зураг, төсвөөс зөрүүтэй гүйцэтгэсэн	-					1	

	байна. /барилгын ажлын баталгаат хугацаанд зөрчлийг арилгах, хяналт хийж ажиллах							
10	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс нь захиалагчийн чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн	-					3	
11	Төрөлх Мөрөн ХХК гүйцэтгэгчээр шалгарч гэрээ байгуулсан, санхүүжилт 107.7 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд авсан Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл, Жаргалант, Галт, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Их-Уул, Рашаант сум/ төсөл, арга хэмжээний Багц-1 Хүнсний зориулалттай модон сав худалдан авах, Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр төсөл, арга хэмжээний Багц-2 сэрээт өргөгч худалдан авах төсөл, арга хэмжээнүүд одоог хүртэл хэрэгжээгүй	107.7					1	107.7
12	Хөрөнгө оруулалтад хяналт хийх чиг үүрэг бүхий Санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтэс нь хяналт хэрэгжүүлээгүй	-			1			
13	Хөрөнгө оруулалтад хяналт хийх чиг үүрэг бүхий аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс хяналт хэрэгжүүлээгүй	-			1			
14	16,861.0 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй	-					1	
15	• Хөвсгөл аймгийн ЗДТГ-т бүртгэлтэй 94.1 сая төгрөгийн 20 ширхэг "Жижиг, дунд оврын усалгааны систем"-ийг ямар нэгэн шийдвэргүйгээр Галт, Бүрэнтогтох, Тосонцэнгэл, Рашаант, Эрдэнэбулган, Түнэл, Жаргалант сумдад шилжүүлсэн. • Эрх шилжээгүй хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжсэн "Орон нутгийг дэмжих "Шинэ хөдөө" улсын хэмжээнд" төсөл арга хэмжээний хүрээнд нийлүүлэгдэх 103.3 сая төгрөгийн 7 ширхэг "барша помп" усалгааны системийг биетээр хүлээж аваагүй байхад аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын 2022 оны А/90 дүгээр тушаалаар Бүрэнтогтох, Тосонцэнгэл, Түнэл, Рашаант сумдад хуваарилж бүртгэхээр шийдвэрлэсэн байна.	-			1			
16	Өмнөх онуудад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн ашиглалтыг түүвэрлэн шалгахад 314.3 сая төгрөгийн дараах барилга байгууламж, тоног төхөөрөмжийг одоог болтол зориулалтын дагуу ашиглаж эхлээгүй байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах.	314.3			1	314.3		
17	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг түрээслүүлэн олсон 301.5 сая төгрөгийг үйл ажиллагааны урсгал зардалд зарцуулж хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулсан	-			1		2	
18	Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн биелүүлээгүйгээс зөрчил давтагдан гарсан /ХБТХОХ/	-			1			
НИЙТ ДҮН		1,000.5	1	6.7	8	496.2	8	107.7

Хавсралт № 1

Барилгын материалын үнийн зөрүү, үлдэгдэл санхүүжилт батлагдсан төсөл, арга хэмжээний жагсаалт

№	Төсөл арга хэмжээний нэр	Нийт төсөвт өртөг	Материалын үнийн зөрүү	Үлдэгдэл санхүүжилт	Гүйцэтгэгчийн нэр
1	Сумын төвийн бетон авто зам, 8.3 км авто замын эхлэлийн 2 км бетон авто зам /Хөвсгөл, Тариалан сум/	2,766.8	266.7	500.0	"Хөвсгөл АЗЗА" ХХК
2	Аймаг, сумын ЗДТГ-ын тоног төхөөрөмж/Хөвсгөл/	50.0	-	50.0	Ай Ти Зон ХХК
3	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл, Ховд/ - багц 1 Жаргалант сумын Цэцүүх багт багт баригдах Багийн төвийн барилга	511.3	-	511.3	БДЗ ХХК
	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл, Ховд/ - багц 2 Жаргалант сумын Цагаанбургас багт баригдах Багийн төвийн барилга		-		БДЗ ХХК
4	Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж /Хөвсгөл/ - Багц 1 - Хүнсний ногоо, даршлах тоног төхөөрөмж худалдан авах	220.4	-	160.4	Зээш гарден ХХК
	Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж /Хөвсгөл/ - Багц 2 - Газар, тариаланд ашиглах дугуйт трактор, тоног төхөөрөмж их бүрдэл нийлүүлэх		-		Мөнх ногоон тал ХХК
5	Аялал жуулчлал, мэдээлэл сурталчилгааны "Соёмбо" цогцолборын дэд бүтэц, тохижилт /Хөвсгөл, Мөрөн сум/	837.4	-	30.4	
6	Жижи, дунд оврын усалгааны систем /Хөвсгөл, Галт, Бүрэнтогтох, Тосонцэнгэл, Рашаант, Эрдэнэбулган, Түнэл, Жаргалант сум/	94.5	-	44.5	Колортийм ХХК
7	Цэцэрлэгийн барилга (50 ор Мөрөн сум)	1,201.9	52.6	-	Сант-Өндөр ХХК
8	"Соёмбо" цэцэрлэгт хүрээлэн /Хөвсгөл, Мөрөн сум/	2,293.1	294.0	-	Сант-Өндөр ХХК
9	Дархадын хотгорын цөлжилтийг бууруулах, Цойцон нуурыг нөхөн сэргээх /Хөвсгөл, Ренчинлхүмбэ сум/	1,026.9	73.3	243.6	Престиж Инженеринг ХХК
10	Халуун усны барилга /Алаг-Эрдэнэ сум/	648.3	79.3	-	Төрөлх Мөрөн ХХК
	Халуун усны барилга /Баянзүрх сум/		81.9	-	Төрөлх Мөрөн ХХК
11	Ахмадын өргөөний барилга /Баянзүрх сум/	1,476.2	-	117.3	Анубулаг ХХК
	Ахмадын өргөөний барилга /Чандмань-Өндөр сум/		281.7	23.1	Тэмээн ХХК
	Ахмадын өргөөний барилга /Цагаан-Үүр сум/		281.7	22.4	Тэмээн ХХК
12	Засаг даргын тамгын газрын барилга /Цагаан-Үүр сум/	1,588.2	394.1	-	Тэмээн ХХК
13	Сургуулийн барилга, спорт заал, 320 суудал /Хөвсгөл, Их-Уул сум/	4,853.1	716.0	-	Уул Өвгөд ХХК
14	Ахмадын өргөөний барилга /Мөрөн сум 11-р баг/	408.7	16.8	-	Хөвсгөл Эх ХХК
	Ахмадын өргөөний барилга /Мөрөн сум 13-р баг/		20.2	-	Хөвсгөл Эх ХХК
15	Засаг даргын тамгын газрын барилга /Түнэл сум/	2,279.7	491.1	-	Цэгц мандал ХХК
16	"Гэр хорооллын хэсэгчилсэн инженерийн хангамжтай жишиг гудамж төсөл" /Хөвсгөл Мөрөн сум/	1,830.3	53.8	-	Төрөлх Мөрөн ХХК
17	Бэлчээрийн усан хангамж /Хөвсгөл, Түнэл, Тосонцэнгэл, Рашаант, Бүрэнтогтох, Их-Уул, Төмөрбулаг, сум/	198.3	-	98.3	Хөвсгөл геологи ХХК
18	Хэрээтийн даваа, Бийжийн даваа, Бор бургасын давааны зам засварын зураг төсөв /Хөвсгөл, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сум/	260.9	-	200.9	Ангад арвижих ХХК
Нийт дүн		22,546.9	3,103.3	2,002.3	

Хавсралт № 2

Санхүүжилтийн гүйцэтгэл

	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Гүйцэтгэгч байгууллагын нэр	2023 олгосон санхүүжилт	Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан
1	Засаг даргын Тамгын газрын барилга /Хөвсгөл, Цагаан-Үүр сум/	1,588.2	Тэмээн ХХК	390.4	79.6
2	Засаг даргын Тамгын газрын барилга /Хөвсгөл, Түнэл сум/	2,279.7	Цэгц мандал ХХК	491.1	24.5
3	Аймаг, сумын ЗДТГ-ын тоног төхөөрөмж/Хөвсгөл/	50.0	Ай Ти Зон ХХК	50.0	2.1
4	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл, Ховд/ - багц 1 Жаргалант сумын Цэцүүх багт багт баригдах Багийн төвийн барилга	511.3	БДЗ ХХК	249.8	12.5
	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл, Ховд/ - багц 2 Жаргалант сумын Цагаанбургас багт баригдах Багийн төвийн барилга		БДЗ ХХК	249.8	12.5
5	Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж /Хөвсгөл/ - Багц 1 - Хүнсний ногоо, даршлах тоног төхөөрөмж худалдан авах	220.4	Зээш гарден ХХК	53.4	-
	Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж /Хөвсгөл/ - Багц 2 - Газар, тариаланд ашиглах дугуйт трактор, тоног төхөөрөмж иж бүрдэл нийлүүлэх		Мөнх ногоон тал ХХК	107.0	-
6	Жижиг, дунд оврын усалгааны систем /Хөвсгөл, Галт, Бүрэнтогтох, Тосонцэнгэл, Рашаант, Эрдэнэбулган, Түнэл, Жаргалант сум/	94.5	Колортийм ХХК	44.1	4.7
7	Бэлчээрийн усан хангамж /Хөвсгөл, Түнэл, Тосонцэнгэл, Рашаант, Бүрэнтогтох, Их-Уул, Төмөрбулаг, сум/	198.3	Хөвсгөл геологи ХХК	63.0	9.9
8	Гэр хорооллын хэсэгчилсэн инженерийн хангамжтай жишиг гудамж төсөл /Хөвсгөл, Мөрөн сум/	1,830.3	Төрөлх Мөрөн ХХК	53.8	2.7
9	Нийтийн халуун усны барилга /Хөвсгөл, Алаг-Эрдэнэ сум/ - багц 1	648.3	Төрөлх Мөрөн ХХК	79.3	-
	Нийтийн халуун усны барилга /Хөвсгөл, Баянзүрх/ - багц 2		Төрөлх Мөрөн ХХК	82.0	-
10	Сургуулийн барилга, спорт заал, 320 суудал /Хөвсгөл, Их-Уул сум/	4,853.1	Уул-Өвгөд ХХК	716.0	242.6
11	Цэцэрлэгийн барилга, 50 ор /Хөвсгөл, Мөрөн сум/	1,201.9	Сант-Өндөр ХХК	52.6	-
12	Дархадын хотгорын цөлжилтийг бууруулах, Цойцон нуурыг нөхөн сэргээх /Хөвсгөл, Ренчинлхүмбэ сум/	1,026.9	Престиж инженеринг ХХК	139.1	42.5
13	"Соёмбо" цэцэрлэгт хүрээлэн /Хөвсгөл, Мөрөн сум/	2,294.0	Сант-Өндөр ХХК	294.0	229.3
14	Аялал жуулчлал, мэдээлэл сурталчилгааны "Соёмбо" цогцолборын дэд бүтэц, тохижилт /Хөвсгөл, Мөрөн сум/	837.4	"Хүслэнт бүтээмж" ХХК "Жемн" ХХК "Хөвсгөл цэнгэг ус" ХХК "Хан атрибут" ХХК "ЗЭТ ЖИ ПИ" ХХК	30.4	30.4
15	Ахмадын өргөөний барилга /Хөвсгөл, Мөрөн сум, 10, 11, 12, 13, 14 дүгээр баг/- багц 1 - 11 дүгээр багийн Ахмадын өргөө	408.7	Хөвсгөл-Эх ХХК	16.8	0.8
	Ахмадын өргөөний барилга /Хөвсгөл, Мөрөн сум, 10, 11, 12, 13, 14 дүгээр баг/- багц 2 - 13 дугаар багийн Ахмадын өргөө		Хөвсгөл-Эх ХХК	20.2	1.0
16	Ахмадын төвийн барилга /Хөвсгөл, Баянзүрх/ багц - 1	1,476.2	Ану булаг ХХК	-	-
	Ахмадын төвийн барилга /Хөвсгөл, Чандмань-Өндөр сум/ - багц 2		Тэмээн ХХК	304.8	56.9
	Ахмадын төвийн барилга /Хөвсгөл, Цагаан-Үүр/ - багц 3		Тэмээн ХХК	304.1	56.4
17	Хэрээтийн даваа, Бийжийн даваа, Бор бургасын давааны зам засварын зураг төсөв /Хөвсгөл, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сум/	260.9	Ангад арвижих ХХК	198.6	-
18	Сумын төвийн бетон авто зам, 8.3 км /Хөвсгөл, Тариалан сум/ - багц 1 - Төв замаас 2 км бетон зам тавих	2,766.8	Хөвсгөл АЗЗА ТӨХК	766.8	138.3
НИЙТ ДҮН		22,546.9		4,757.2	946.8

Хавсралт № 3

Хэрэгжиж дууссан нягтлан бодох бүртгэлд тусгасан болон тусгаагүй төсөл, арга хэмжээний жагсаалт

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Хүлээн авсан актын огноо	НББ-д бүртгэсэн эсэх	НББ-д бүртгэсэн үнийн дүн
1	Засаг даргын Тамгын газрын барилга /Хөвсгөл, Цагаан-Үүр сум/	1,588.2	2023.12.07	үгүй	-
2	Засаг даргын Тамгын газрын барилга /Хөвсгөл, Түнэл сум/	2,279.7	2022.09.27	үгүй	-
3	Аймаг, сумын ЗДТГ-ын тоног төхөөрөмж/Хөвсгөл/	50.0	2022.04.25	тийм	41.1
4	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл, Ховд/ - багц 1 Жаргалант сумын Цэцүүх багт багт баригдах Багийн төвийн барилга	511.3	2023.09.29	үгүй	-
	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл, Ховд/ - багц 2 Жаргалант сумын Цагаанбургас багт баригдах Багийн төвийн барилга		2023.09.29	үгүй	-
5	Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж /Хөвсгөл/ - Багц 1 - Хүнсний ногоо, даршлах тоног төхөөрөмж худалдан авах	220.4	2022.12.16	тийм	96.3
	Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж /Хөвсгөл/ - Багц 2 - Газар, тариаланд ашиглах дугуйт трактор, тоног төхөөрөмж иж бүрдэл нийлүүлэх		2022.09.04	тийм	198.5
6	Жижиг, дунд оврын усалгааны систем /Хөвсгөл, Галт, Бүрэнтогтох, Тосонцэнгэл, Рашаант, Эрдэнэбулган, Түнэл, Жаргалант сум/	94.5	2022.12.15	тийм	94.1
7	Бэлчээрийн усан хангамж /Хөвсгөл, Түнэл, Тосонцэнгэл, Рашаант, Бүрэнтогтох, Их-Уул, Төмөрбулаг, сум/	198.3	2023.01.06 2023.01.04 2023.01.06 2023.01.04 2023.01.05	үгүй	-
8	Гэр хорооллын хэсэгчилсэн инженерийн хангамжтай жишиг гудамж төсөл /Хөвсгөл, Мөрөн сум/	1,830.3	2020.12.14	үгүй	-
9	Сургуулийн барилга, спорт заал, 320 суудал /Хөвсгөл, Их-Уул сум/	4,853.1	2023.11.08	Үгүй	-
10	Цэцэрлэгийн барилга, 50 ор /Хөвсгөл, Мөрөн сум/	1,201.9	2024.01.08	үгүй	-
11	Дархадын хотгорын цөлжилтийг бууруулах, Цойцон нуурыг нөхөн сэргээх /Хөвсгөл, Ренчинлхүмбэ сум/	1,026.9	2022.10.08	үгүй	-
12	Аялал жуулчлал, мэдээлэл сурталчилгааны "Соёмбо" цогцолборын дэд бүтэц, тохижилт /Хөвсгөл, Мөрөн сум/	837.4		тийм	837.4
13	Ахмадын өргөөний барилга /Хөвсгөл, Мөрөн сум, 10, 11, 12, 13, 14 дүгээр баг/- багц 1 - 11 дүгээр багийн Ахмадын өргөө	408.7	2020.10.12	үгүй	-
	Ахмадын өргөөний барилга /Хөвсгөл, Мөрөн сум, 10, 11, 12, 13, 14 дүгээр баг/- багц 2 - 13 дугаар багийн Ахмадын өргөө		2020.11.26	үгүй	-
14	Хэрээтийн даваа, Бийжийн даваа, Бор бургасын давааны зам засварын зураг төсөв /Хөвсгөл, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сум/	260.9	2023.02.06	үгүй	-
15	Сумын төвийн бетон авто зам, 8.3 км /Хөвсгөл, Тариалан сум/ - багц 1 - Төв замаас 2 км бетон зам тавих	2,766.8	2023.11.20	үгүй	-
НИЙТ ДҮН		18,128.4			1,267.4

Санал ирүүлсэн байгууллага, албан тушаалтан	Санал	Санал шийдвэрлэсэн байдал
Аймгийн Засаг дарга	МОНГОЛ УЛС ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА АЗДТГ-ын байр, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120 Утас: 7038 2300, 7038 3303, факс: 7038 1001 Цахим шуудан: huvsgulzdtg@khs.gov.mn Цахим хуудас: www.khovsgol.gov.mn _____ № _____ таний _____ -ны № _____ -т ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлангийн төсөлтэй холбоотой саналгүй болно. Зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллана. П.ЛХАГВАЖАВ My Door jlig foot 6712070733	Санал ирүүлээгүй
Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга	ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР АЗДТГ-ын байр, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120 Утас: 70383303 Факс: Цахим шуудан: huvsgulzdtg@khs.gov.mn Цахим хуудас: https://khovsgol.gov.mn/ 2024.04.19 № 3/741 таний _____ -ны № _____ -т ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлангийн төсөлтэй холбоотой саналгүй болно. Хөвсгөл аймгийн засаг даргын тамгын газар Засаг даргын тамгын газар Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Бямбажав Батбилүүн 2024-04-19 18:36:48	Санал ирүүлээгүй

--ooOoo--



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 04 сарын 19 өдөр

№ 90/22270438/ХӨА-2024/
28-21-ШТА-ГА

Мөрөн сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сумдын Ахмадын төвийн барилгыг баталгаажсан зураг, төсвөөс зөрүүтэй 60 см намхан барьсан байхад санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйл 14.1.1-т “Барилга байгууламж дараах шаардлагыг хангасан байна: зураг төслийн дагуу баригдсан байх;”, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.8.23-т “Энэ журмын 4.8.22-т зааснаар санхүүжилтийг гүйцэтгэгч байгууллага руу олгосноос гарах аливаа эрсдэл, үр дагаврыг гүйцэтгэлийн санхүүжилтийг хянан баталгаажуулж ирүүлсэн захиалагч байгууллага хариуцна;” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ханын дутуу хийгдсэн ажлын материалын 6,658,200 /зургаан сая зургаан зуун тавин найман мянга хоёр зуу/ төгрөгийг Тэмээн ХХК-аар төлүүлж Хөвсгөл аймгийн төрийн санд байрших 100170000955 тоот /Хө. Бусад нэр заагдаагүй орлого/ дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ нотлох баримтын хамт ирүүлэхийг Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Оюунтуяа, мэргэжилтэн Х.Буянтогтох нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

З.ДАВААДОРЖ

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 303 тоот

6724020316



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 04 сарын 19 өдөр

№ 71/А2270438/ХӨА-2024/
28-21-ШТА-ГА

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Өмнөх аудитаар өгсөн “Төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хүлээн авсан боловч одоо болтол зориулалтын дагуу хэрхэн ашиглах нь тодорхойгүй, холбогдох байгууллагын бүртгэлд байгаа барилга байгууламж, тоног төхөөрөмжийн ашиглалтын чиглэлийг нарийвчлан тогтоож, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлэх” зөвлөмжийг хэрэгжүүлээгүй,
2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн түрээсийн орлого 301.5 сая төгрөг “Хөдөөгийн шийдэл” ХХК-ийн үйл ажиллагааны зардалд зарцуулагдсан байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ.” гэж заасантай нийцэхгүй байна

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-т “аудитаар илэрсэн алдаа зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол,” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн ашиглалтыг сайжруулан, үр өгөөжийг нэмэгдүүлж биелэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэх,

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөвсгөл аймгийн П.Лхагважавт даалгав

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭВДЭНЭБААТАР

АХЛАХ АУДИТОР Э.ДАВААДОРЖ

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг, аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 303 тоот

6724070294



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 04 сарын 19 өдөр

№ 72/АД270437/ХӨА-2024/28-21-ШТА-ГА Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх онд гүйцэтгэсэн “Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар хүргүүлсэн “Төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хүлээн авсан боловч одоо болтол зориулалтын дагуу хэрхэн ашиглах нь тодорхойгүй, холбогдох байгууллагын бүртгэлд байгаа барилга байгууламж, тоног төхөөрөмжийн ашиглалтын чиглэлийг нарийвчлан тогтоож, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлэх” зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн ашиглалтыг түүвэрлэн шалгахад 604.0 сая төгрөгийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг одоог болтол зориулалтын дагуу ашиглаж эхлээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ.” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-д “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд хэрэгжүүлээгүй бол” заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон 604.0 сая төгрөгийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг одоог болтол зориулалтын дагуу ашиглаж эхлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹-т ирүүлэх;
2. Цаашид тус алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмжийн зориулалтын дагуу ашиглаж, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга (П.Лхагважав)-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР
Н.ГҮРБААЗАР

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг, аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 303 тоот

6724030278



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 04 сарын 19 өдөр

№ 83/А227С437/ХӨА-2024/28-21-ШТА-ГА Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх онд гүйцэтгэсэн “Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар хүргүүлсэн “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах, гэрээний заалтыг биелүүлээгүй аж ахуйн нэгжид гэрээнд заасан хариуцлагын арга хэмжээг авах” зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчил давтагдан гарсан байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ.” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-д “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд хэрэгжүүлээгүй бол” заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹-т ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Батбилгүүн)-д, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа)-д нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР
Н.ГҮРБАЗАР

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг, аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 303 тоот

6724030286



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 04 сарын 19 өдөр

№ 74/А2270437/ХӨА-2024/28-21-ШТА-ГА

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрх шилжээгүй улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжсэн “Орон нутгийг дэмжих “Шинэ хөдөө” (улсын хэмжээнд) төсөл арга хэмжээний хүрээнд нийлүүлэгдэх 103.3 сая төгрөгийн 7 ширхэг “Барша помп” усалгааны системийг биетээр хүлээж аваагүй байхад аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын 2022 оны А/90 дүгээр тушаалаар Бүрэнтогтох, Тосонцэнгэл, Түнэл, Рашаант сумдад хуваарилж бүртгэх шийдвэр гаргаж тус сумд Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэсэн бөгөөд одоог болтол тус хөрөнгийг биетээр хүлээж аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх;” Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 “Төрийн өмчийн эд хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан журмаар үнэлж бүртгэнэ.” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эрх шилжээгүй улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжсэн “Орон нутгийг дэмжих “Шинэ хөдөө”(улсын хэмжээнд) төсөл арга хэмжээний хүрээнд нийлүүлэгдэх 103.3 сая төгрөгийн 7 ширхэг “Барша помп” усалгааны системийг биетээр хүлээж аваагүй байхад нягтлан бодох бүртгэлд тусгасан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 20-ний өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹ т ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга (Х.Цэнд-Аюуш)-д хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР
Н.ГҮРБАЗАР

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг, аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 302 тоот, Утас: 7038-4043

6724030289



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 04 сарын 19 өдөр

№ 75/АЭТТ0457/ХӨА-2024/28-21-ШТА-ГА Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар өгсөн “Төсвийн хөрөнгө оруулалтад хяналт хийж үнэлгээ өгч ажиллах” зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ.” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг төсөл зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-д “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд хэрэгжүүлээгүй бол” заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсвийн хөрөнгө оруулалтад хяналт хийж үнэлгээ өгөөгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹-т ирүүлэх;
2. Цаашид тус алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга (Д.Нямжав)-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР
Н.ГҮРБАЗАР

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг, аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 303 тоот

6724030292



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 04 сарын 19 өдөр

№ 76/А2270438/ХӨА-2024/
28-21-ШТА-ГА

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад хяналт хийж ажиллаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 5.2.4-т “Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн эрхтэй дотоод аудитор буюу санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч нь энэ журмын 5.1-д зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашгийн байдалд хяналт тавих;” гэж заасантай нийцэхгүй байна

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад хяналт хийж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 01 дугаар сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹-т ирүүлэх,

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөвсгөл аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Догсмоод даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

АХЛАХ АУДИТОР

З.ДАВААДОРЖ

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг, аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 303 тоот

6724030273



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 04 сарын 19 өдөр

№ 77/А2870438/ХӨА-2024/
28-21-ШТА-ГА

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Алаг-Эрдэнэ, Баянзүрх сумдын Нийтийн халуун усны барилга төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй, барилгын ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгүүлээгүй, барилгын ханын ажлыг зураг, төсөвт туссанаар 15-ыг харьцах 15-ын харьцаатай балк модоор барих ёстой байтал 12-ыг харьцах 15-ын харьцаатай балк модоор барьсан байна.

Энэ нь Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.6-д “Захиалагч зураг төсөл зохиогч болон гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг тогтоосон хугацаанд дүгнэж, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч гэрээний дагуу хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, эсхүл зөрчил, дутагдал илэрсэн тохиолдолд гэрээ болон хууль тогтоомжид заасан хариуцлагыг тооцож ажиллана.”, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.4.1.5-д “Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний захиалагчийн техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллага нь холбогдох хууль тогтоомжид заасны дагуу техник, технологийн захиалагчийн хяналт хэрэгжүүлэх зөвшөөрлийг авсан байх бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: захиалагчийн техник, технологийн хяналтыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу мэргэжлийн түвшинд, чанартай, үр ашигтай, ил тод, нээлттэй болон хэмнэлттэй байдлаар хэрэгжүүлэх,” гэж заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Алаг-Эрдэнэ, Баянзүрх сумдын Нийтийн халуун усны барилгыг гэрээ, зураг, төслийн дагуу гүйцэтгүүлж, хугацаа хоцорсон зөрчилд гэрээний хариуцлага тооцож, биелэлтийг 2024 оны 11 дугаар сарын 15-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹ т ирүүлэх,

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөвсгөл аймгийн Барилга захиалагчийн хяналтын төв ААТҮГ-ын захирал Х.Даваасүрэнд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР
З.ДАВААДОРЖ

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг, аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 303 тоот

6724030269



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 04 сарын 19 өдөр

№ 78/А2270438/ХӨА-2024/
28-21-ШТА-ГА

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цагаан-Үүр, Чандмань-Өндөр, Баянзүрх сумдын Ахмадын төвийн барилга төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй, барилгын ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгүүлээгүй, Чандмань-Өндөр сумын Ахмадын төвийн барилгын шат, суурийн хаяавчинд хагарал өгсөн байдалтай байна.

Энэ нь Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.6-д “Захиалагч зураг төсөл зохиогч болон гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг тогтоосон хугацаанд дүгнэж, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч гэрээний дагуу хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, эсхүл зөрчил, дутагдал илэрсэн тохиолдолд гэрээ болон хууль тогтоомжид заасан хариуцлагыг тооцож ажиллана.”, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.4.1.5-д “Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний захиалагчийн техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллага нь холбогдох хууль тогтоомжид заасны дагуу техник, технологийн захиалагчийн хяналт хэрэгжүүлэх зөвшөөрлийг авсан байх бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: захиалагчийн техник, технологийн хяналтыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу мэргэжлийн түвшинд, чанартай, үр ашигтай, ил тод, нээлттэй болон хэмнэлттэй байдлаар хэрэгжүүлэх,” гэж заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цагаан-Үүр, Чандмань-Өндөр, Баянзүрх сумдын Ахмадын төвийн барилгыг гэрээ, зураг, төслийн дагуу гүйцэтгүүлж, хугацаа хоцорсон зөрчилд гэрээний хариуцлага тооцож биелэлтийг 2024 оны 11 дугаар сарын 15-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэх,

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөвсгөл аймгийн Барилга захиалагчийн хяналтын төв ААТҮГ-ын захирал Х.Даваасүрэнд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР
З.ДАВААДОРЖ

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг, аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 303 тоот

6724030265